



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 171

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Алтай-Улиастай эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 239,367,800 (хоёр зуун гучин есөн сая гурван зуун жаран долоон мянган найман зуун) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Алтай-Улиастай эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын биелэлтээр “Алтай-Улиастай эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компани нь 89.7 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээ авсан байх тул цаашид биелэлтийг 100 хувь хангаж ажиллах;

3.“Алтай-Улиастай эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах;

3.2.Гүйцэтгэх захиралтай байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ” болон “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

4.“Алтай-Улиастай эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Бүрэн эрхт төлөөлөгч (Х.Бекболат)-д дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

4.1.Шалгалтын тайланд дурдсан зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

4.2.Компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч өмчлөлийн маргаантай, иргэн Л.Хаш-Эрдэнийн эзэмшилд ашиглагдаж байгаа 3 өрөө орон сууцны байрын асуудлыг хууль хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

4.3.Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг нормд заасны дагуу барилга байгууламжийн эдэлгээний хугацаанд үзлэг шалгалтыг хийж хувийн хэргийн хөтлөлтийг сайжруулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.2.1-т заасны дагуу "...хувийн хэрэг хөтлөх" гэснийг мөрдөж ажиллах;

4.4.“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат толгой компанийн үндсэн хөрөнгийн дансны ангилал зөрүүлж бүртгэсэн 19 нэр төрлийн 40.4 (дөчин сая дөрвөн зуун мянган) сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 1.2 дахь заалтын дагуу залруулж бүртгэх;

4.5.“Алтай-Улиастай эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн охин компани болох “Богдын гол” ХХК-ийн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн дансны үлдэгдэл, санхүүгийн тайлангийн үлдэгдэл 170.2 (нэг зуун далан сая хоёр зуун мянган) сая төгрөгийн тоног төхөөрөмж, 4.6 (дөрвөн сая зургаан зуун мянган) сая төгрөгийн тавилга эд хогшил, нийт 174.8 (нэг зуун далан дөрвөн сая найман зуун мянган) сая төгрөгөөр зөрсөн тул зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

4.6.Компанийн эзэмшилд байгаа, өмнө конторын зориулалтаар ашиглагдаж байсан 435.0 м.кв талбай бүхий 2 давхар тоосгон барилгын ашиглалтыг сайжруулах;

4.7.“Алтай-Улиастай эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн охин компани болох “Тосонцэнгэл усан цахилгаан станц” ХХК-ны санхүүгийн баримтад дотоод хяналт шалгалтыг оруулж, байгууллагад учирсан хохирлыг холбогдох албан тушаалтнаар төлүүлэх, хариуцлага тооцох, шаардлагатай тохиолдолд Авлигатай тэмцэх газарт шилжүүлж шалгуулах;

4.8.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

5.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд, багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

6.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2023 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн
177 дугаар тогтоолын хавсралт



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах
арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Дүн /мян.төг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Үндсэн хөрөнгийн дансны ангиллыг зөрүүлсэн	40,400.0	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах
2	Бусдад ашиглуулж буй байгууллагын дансанд бүртгэлтэй орон сууц	24,167.8	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний заалтыг мөрдөж ажиллах
3	"Алтай-Улиастай эрчим хүчний систем" ТӨХК-ийн охин компани болох "Богдын гол" ХХК-ийн үндсэн хөрөнгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын үлдэгдэл зөрүүтэй	174,800.0	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах
4	Компанийн эзэмшилд байгаа, өмнө конторын зориулалтаар ашиглагдаж байсан 435.0 м.кв талбай бүхий 2 давхар тоосгон барилга ашиглалтгүй байна.	-	Худалдан борлуулах буюу түрээсийн хэлбэрээр ашиглалтыг сайжруулах
	Нийт дүн		239,367.8 (хоёр зуун гучин есөн сая гурван зуун жаран долоон мянган найман зуун)